



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/281

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Хот байгуулалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Барилга, хот байгуулалтын Сайдын 2019 оны 38 дугаар тушаалаар баталсан “Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам”-ын 4.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Хот байгуулалтын кадастрын хэлтэс /Г.Цогтсайхан/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар /Р.Ганхуяг/-т тус тус даалгасугай.


ДАРГА



Ц.ГАНХҮҮ

08 192227

Газар зохион байгуулалт, геодези,
зураг зүйн газрын даргын 2019 оны
А/281 дугаар тушаалын хавсралт



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Улсын хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хот байгуулалтын кадастрын баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлоход энэ журмын зорилго оршино.

1.1. Эрх зүйн үндэслэл

Хот байгуулалтын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Барилга, хот байгуулалтын Сайдын 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тушаалаар баталсан “Хот байгуулалтын кадастр” БД 14-102-19, Барилга, хот байгуулалтын Сайдын 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 38 дугаар тушаалаар баталсан “Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам”-ын 4.5 дахь заалт, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан ‘Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагаа болон тайланд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ыг тус тус үндэслэв.

1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

- 1.2.1. Хот байгуулалтын кадастрын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах;
- 1.2.2. Хот байгуулалтын мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, төлөвлөлтийг сайжруулах;
- 1.2.3. Тухайн жилд шинээр болон их засвар, өргөтгөл, шинэчлэл хийсэн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн болон нийгмийн дэд бүтцийн мэдээллийн шинэчлэлт, баяжилт хугацаандаа шинэчлэгдсэн байдалд хяналт тавих;
- 1.2.4. Мэдээллийн сангийн өгөгдөл үнэн, зөв, бүрэн бүртгэгдсэн байдалд хяналт тавих;
- 1.2.5. Хот байгуулалтын кадастрын баримт бичгийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, мэдээллийг архивласан байдалд хяналт тавих;



1.2.6. Хот байгуулалтын баримт бичгийн хэрэгжилттэй холбогдох шинэ ололт амжилтыг бусдад түгээх дэлгэрүүлэх, сурталчилах, туршлага хуваалцах, цаашид авах арга хэмжээг тодорхойлох;


1.3. Нэр томъёоны тодорхойлолт

1.3.1. Энэхүү журамд дараах үндсэн ойлголтуудыг ашигласан болно. Үүнд:

- **Хот байгуулалтын кадастр** гэж нутаг дэвсгэрийн ашиглалт, хүрээлэн буй орчны төлөв байдал, засаг захиргааны нэгж, инженер-геологийн нөхцөл, инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хангамжийн түвшин, барилга байгууламж, хүн амын амьдрах орчны байр зүйн болон газарзүйн зураглал, мэдээллийн улсын нэгдмэл санг;
- **Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан** гэж орон зайн өгөгдөл, техник, програм хангамж, техникийн програм, хууль, эрх зүй, зохион байгуулалтын арга барилыг багтаасан мэдээллийн технологи, шалгалт, бүртгэл, тооллого, хадгалалт, ашиглалтын бүхий мэдээллийн цогцыг;
- **Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагаа** гэж Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, ашиглуулахыг;
- **Хот байгуулалтын кадастрын мэдээлэл солилцох байгууллага** гэж “Хот байгуулалтын кадастр” БД 14-102-19-ын 5-д заагдсаныг.
- **Орон зайн өгөгдөл** гэж газрын гадаргын дээрх, доорх, ус, агаар, сансрын орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байршил, хэмжээ, шинж чанарыг тодорхойлж буй өгөгдлийг;
- **Орон зайн мэдээлэл** гэж орон зайн өгөгдлөөс шийдвэр гаргах зорилгоор боловсруулан гаргаж авсан мэдээллийг;
- **Кадастрын лавлагаа** гэж хот байгуулалтын кадастрын талаарх албан ёсны баримт бичиг бөгөөд хүсэлт гаргасан хэрэглэгчийн өмчлөл, эзэмшлийн газрын зориулалт, хот байгуулалтын зөвшөөрөгдөх, хориглох болон хязгаарлах үйл ажиллагааны талаарх мэдээлэл, тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгө, кадастрын бусад төрлийн мэдээллийг зураг болон хүснэгтэн байдлаар гаргасан тодорхойлолтыг ойлгоно.

1.4. Хамрах хүрээ

1.4.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагаанд Хот байгуулалтын кадастрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт-шинжилгээ, үнэлгээг хийнэ.



1.4.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн Ерөнхий архитектор, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын асуудал хариуцсан болон холбогдох мэргэжилтэнтэй хамтран явуулна.

1.4.3. Хот байгуулалтын кадастрын мэдээлэл солилцох байгууллагуудаас гаргаж ирүүлсэн цаасан болон цахим өгөгдөлд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, АРГА ЗҮЙ

2.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний төрөл

2.1.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ нь дараах хоёр төрөлтэй байна. Үүнд:

- ❖ Төлөвлөгөөт хяналт-шинжилгээ, үнэлгээ
- ❖ Төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээ

1. Төлөвлөгөөт хяналт-шинжилгээ, үнэлгээ

Төлөвлөгөөт хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдах газар, хэрэгжүүлэх хугацаа, зардал зэргийг тусган агентлагын даргаар жил бүрийн I улиралд багтаан батлуулна.

Төлөвлөгөөт хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүрийн 3-аас 4 дүгээр сард, 9-өөс 10 дугаар сард, жилдээ 2 удаа, улсын хэмжээнд гүйцэтгэнэ.

2. Төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээ


Төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээг хот байгуулалтын баримт бичгийн хэрэгжилт хангалтгүй бол, аймгийн холбогдох байгууллагаас гаргасан санал хүсэлт ирүүлсэн, маргаан үүсгэсэн гэх мэт шаардлагатай тохиолдолд хийж гүйцэтгэнэ.

Төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, чиглэл, хамрах хүрээ, бүрэлдэхүүн, хугацааг агентлагийн даргаар батлуулсан удирдамжийн дагуу гүйцэтгэнэ.

2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

2.2.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн болон нийгмийн дэд бүтцийн мэдээлэл тус бүрээс түүвэрлэн, хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэнэ.

2.2.2. Хүснэгт№1-д тавигдах шалгуур үзүүлэлт, зарчмаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийнэ.



Шалгуур үзүүлэлт, оноо

Хүснэгт №1

Шалгуур үзүүлэлт	Үнэлэх зарчим	Харгалзах оноо
Бүрэн байдал	Өгөгдөл бүрдүүлэх маягтын нийт үзүүлэлтээс бүрдүүлсэн өгөгдлөөр пропорцийн аргаар тооцон хувиар илэрхийлнэ.	0-100%
Хугацаандаа мэдээлэл бүртгэсэн байдал	Өгөгдөл мэдээллийг шинэчлэх хугацаанаас 5-н сараас дээш хугацаанд мэдээллийн санд бүртгэсэн;	20 %
	Өгөгдөл мэдээллийг шинэчлэх хугацаанаас 4-өөс 5-н сарын дараа мэдээллийн санд бүртгэсэн;	35%
	Өгөгдөл мэдээллийг шинэчлэх хугацаанаас 3-аас 4-н сарын дараа мэдээллийн санд бүртгэсэн;	50 %
	Өгөгдөл мэдээллийг шинэчлэх хугацаанаас 2-оос 3-н сарын дараа мэдээллийн санд бүртгэсэн;	65%
	Өгөгдөл мэдээллийг шинэчлэх хугацаанаас 1-ээс 2 сарын дараа мэдээллийн санд бүртгэсэн;	80%
	Өгөгдөл мэдээллийн шинэчлэлийг хугацаанд нь бүртгэсэн;	100%
Үнэн, зөв байдал	Бүрдүүлсэн өгөгдлөөс илт буруу, баталгаажаагүй, баталгаажсан утгыг мэдээллийн санд буруу бүртгэсэн, нягтлан шалгаагүй мэдээллийн санд оруулсан гэх мэт өгөгдлийг алдаа гэж үзэн бүртгэсэн өгөгдлийн дүнгээс хасч, пропорцийн аргаар тооцон, хувиар илэрхийлнэ.	0-100%
Хадгалалт	Хот байгуулалтын кадастрын мэдээлэл солилцох байгууллагаас цахимаар болон цаасан байдлаар өгөгдөл бүрдүүлэх маягтын дагуу гаргуулсан боловч баталгаажуулаагүй, архивлаагүй бол;	50%
	Хот байгуулалтын кадастрын мэдээлэл солилцох байгууллагаас цахимаар болон цаасан байдлаар өгөгдөл бүрдүүлэх маягтын дагуу гаргуулсан, баталгаажуулсан боловч холбогдох дүрэм журмын дагуу архивлаагүй бол;	70%
	Хот байгуулалтын кадастрын мэдээлэл солилцох байгууллагаас цахимаар болон цаасан байдлаар өгөгдөл бүрдүүлэх маягтын дагуу гаргуулан, баталгаажуулан авч, холбогдох дүрэм журмын дагуу архивласан бол;	100%
*Тухайн он дуусах хүртэлх хугацаанд гүйцэтгэлийн хугацаа болоогүй байгаа ажлын тоо хэмжээг хасаж тооцно.		



2.2.3. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийн бүрдүүлэлтийн ерөнхий үнэлгээ нь үзүүлэлт бүрийн онооны нийлбэрийг нийт үзүүлэлтийн тоонд хувааж гаргасан дундаж оноогоор тодорхойлно.

2.2.4. Хот байгуулалтын мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны хэрэгжилт, дундаж оноог үндэслэн дараах дүгнэлтийг өгнө. Үүнд:

- ❖ “үр дүнтэй” – 80-100 хүртэл хувь;
- ❖ “тодорхой үр дүнд хүрсэн” – 60-80 хүртэл хувь;
- ❖ “эрчимжүүлэх шаардлагатай” – 40-60 хүртэл хувь;
- ❖ “үр дүнгүй” – 40 хүртэл хувь;

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ НЭГТГЭХ, ТАЙЛАГНАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ

3.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, санал, зөвлөмж нь тухайн Газрын үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах, зөрчил, дутагдалын шалтгааныг тогтоох, байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны үр дүнг боловсронгуй болгох, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангахад чиглэнэ.

3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авна. Үүнд:

3.2.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн үр дүнг сайжруулах талаар хугацаатай үүрэг даалгавар, чиглэл, зөвлөмж өгөх;

3.2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний журамаар “эрчимжүүлэх шаардлагатай”, “үр дүнгүй”, “үнэлэх боломжгүй” үнэлгээ авсан аймгуудыг төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулах;

3.2.3. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн сайн туршлага, санаачлагыг сурталчлах, нэвтрүүлэх;


3.2.4. Үр дүнг дээшлүүлэх сайжруулах сургалт зохион байгуулах;

3.2.5. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулахад чиглэгдсэн оновчтой арга хэмжээг үе шаттай төлөвлөн хэрэгжүүлэх;

3.2.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулж, цаашид авах арга хэмжээний шийдвэр гаргуулах;

3.2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх үзүүлэлт болгон ашиглах;

3.2.8. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, санал, зөвлөмжийг аймгийн Засаг дарга болон Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлэн биелэлтийг хангуулах;



3.2.9. Тухайн жилийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг улсын хэмжээнд нэгтгэн Барилга, хот байгуулалтын яам, холбогдох байгууллага, албан тушаалтан иргэдэд мэдээлж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХАРИУЦЛАГА


4.1. Дараах зөрчил гарсан бол Төрийн албаны тухай, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэнэ.

4.1.1. Худал, зөрүүтэй мэдээллээр тайлагнасан;

4.1.2. Өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн эсвэл биелүүлээгүй;

4.1.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр удаа дараалан хангалтгүй үнэлэгдсэн;

4.2. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн хадгалалт, нууцлал, баталгааны хариуцлага алдсан, хувийн зорилгоор ашигласан гэх мэт тохиолдолд зөрчлийн шинж, учруулсан хохирлыг харгалзан зохих хууль, журамд заасны дагуу арга хэмжээ авахаас гадна шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.



ТАВДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Аймгийн нэр:

Хариуцсан албан тушаалтны овог нэр:

Албан тушаал:


20... оны ... сарын ... өдөр

Д/д	Барилга байгууламжийн нэр	Ерөнхий мэдээлэл /29 өгөгдөл/	Барилгын үзүүлэлт /39 өгөгдөл/	Барилгын инженер хангамж /8 өгөгдөл/	Барилгын материал /шинээр ашиглалтад орсон/ /14 өгөгдөл/	Нийт бүртгэсэн өгөгдлийн тоо		Бүрэн байдал	Хугацаандаа бүртгэсэн байдал	Үнэн зөв байдал			Хадгалалт архивлалт	Нийт үнэлгээ	Тайлбар	
						Одоо ашиглагдаж байгаа /76/	Шинээр ашиглалтад орсон /90/			Бүртгэсэн өгөгдөл	Алдаатай өгөгдөл	Үнэлгээ /хувиар/				
1																
2																
3																
4																
5																
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ:																

“Бүртгэгдээгүй өгөгдлийн дугаар:

Хяналт шинжилгээ, үнэлгээ өгсөн албан тушаалтан: /...../

Хяналт шинжилгээ, үнэлгээтэй танилцсан албан тушаалтан: /...../



ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Аймгийн нэр:

Хариуцсан албан тушаалтны овог нэр:

Албан тушаал:


20... оны ... сарын ... өдөр

д/д	Тохижилт, ногоон байгууламжийн нэр	Тохижилт /151 өгөгдөл/	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж /37 өгөгдөл/	Хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламж /37 өгөгдөл/	Тусгай хэрэгцээний ногоон байгууламж /29 өгөгдөл/	Нийт бүртгэсэн өгөгдөлийн тоо	Бүрэн байдал	Хугацаандаа бүртгэсэн байдал	Үнэн зөв байдал			Хадгалалт архивлалт	Нийт үнэлгээ	Тайлбар
									Бүртгэсэн өгөгдөл	Алдаатай өгөгдөл	Үнэлгээ /хувиар/			
1														
2														
3														
4														
5														
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ:														

"Бүртгэгдээгүй өгөгдлийн дугаар:

Хяналт шинжилгээ, үнэлгээ өгсөн албан тушаалтан: /...../

Хяналт шинжилгээ, үнэлгээтэй танилцсан албан тушаалтан: /...../



НИЙГМИЙН ДЭД БҮТЦИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Аймгийн нэр:

Хариуцсан албан тушаалтны овог нэр:

Албан тушаал:


20... оны ... сарын ... өдөр

Д/д	Барилга байгууламжийн төрөл	Хүн амын өсөлт /8 өгөгдөл/	Соёлын барилга /3 өгөгдөл/	Боловсролын байгууллага /3 өгөгдөл/	Худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээний барилга /3 өгөгдөл/	Эмнэлгийн барилга байгууламж /2-4 өгөгдөл/	Нийт бүртгэсэн өгөгдөлийн тоо	Бүрэн байдал	Хугацаандаа бүртгэсэн байдал	Үнэн зөв байдал			Хадгалалт архивлалт	Нийт үнэлгээ	Тайлбар
										Бүртгэсэн өгөгдөл	Алдаатай өгөгдөл	Үнэлгээ /хувиар/			
2															
3															
4															
5															
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ:															

"Бүртгэгдээгүй өгөгдлийн дугаар:

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн албан тушаалтан: /...../

Хяналт шинжилгээ, үнэлгээтэй танилцсан албан тушаалтан: /...../



111

ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Аймгийн нэр:

Хариуцсан албан тушаалтны овог нэр:

Албан тушаал:.....

20... оны ... сарын ... өдөр

д/д	Цахилгаан дамжуулах өндөр нам хүчдэлийн агаарын шугам /16 өгөгдөл/	Цахилгаан дамжуулах өндөр нам хүчдэлийн шугам /газар доорхи/ /13 өгөгдөл/	Цахилгааны худаг /20 өгөгдөл/	Цахилгааны дэд станц /22 өгөгдөл/	Цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын бүс /3 өгөгдөл/	Нийт бүртгэсэн өгөгдөлийн тоо	Бүрэн байдал	Хугацаандаа бүртгэсэн байдал	Үнэн зөв байдал			Хадгалалт архивлалт	Нийт үнэлгээ	Тайлбар
									Бүртгэсэн өгөгдөл	Алдаатай өгөгдөл	Үнэлгээ /хувиар/			
1														
2														
3														
4														
5														
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ:														

“Бүртгэгдээгүй өгөгдлийн дугаар:

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн албан тушаалтан: /...../

Хяналт шинжилгээ, үнэлгээтэй танилцсан албан тушаалтан: /...../



Handwritten mark

ЗАМ ТЭЭВРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Аймгийн нэр:

Хариуцсан албан тушаалтны овог нэр:

Албан тушаал:.....


20... оны ... сарын ... өдөр

Д/Д	Замын байгууламжийн нэр	Үндсэн үзүүлэлт /22 өгөгдөл/	Хуучилтын хийц /2 өгөгдөл/	Гүйцэтгэгч байгууллага /8 өгөгдөл/	Авто замын хамгаалалтын бус /5 өгөгдөл/	Нийт бүртгэсэн өгөгдлийн тоо	Бүрэн байдал	Хугацаандаа бүртгэсэн байдал	Үнэн зөв байдал			Хадгалалт архивлалт	Нийт үнэлгээ	Тайлбар	
									Бүртгэсэн өгөгдөл	Алдаатай өгөгдөл	Үнэлгээ /хувиар/				
1															
2															
3															
4															
5															
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ:															

"Бүртгэгдээгүй өгөгдлийн дугаар:

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн албан тушаалтан: /...../

Хяналт шинжилгээ, үнэлгээтэй танилцсан албан тушаалтан: /...../



**УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГА, ДУЛААН ХАНГАМЖИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Аймгийн нэр:

Хариуцсан албан тушаалтны овог нэр:

Албан тушаал:.....


20... оны ... сарын ... өдөр

д/д	Шугамын төрөл зориулалт	Дамжуулах шугам сүлжээ /26 өгөгдөл/	Түгээх шугам сүлжээ /26 өгөгдөл/	Цуглуулах шугам /26 өгөгдөл/	Татан зайлуулах шугам /26 өгөгдөл/	Дулаан хангамжийн шугам сүлжээ /26 өгөгдөл/	Нийт бүртгэсэн өгөгдлийн тоо	Бүрэн байдал	Хугацаандаа бүртгэсэн байдал	Үнэн зөв байдал			Хадгалалт архивлалт	Нийт үнэлгээ	Тайлбар
										Бүртгэсэн өгөгдөл	Алдаатай өгөгдөл	Үнэлгээ /хувиар/			
1															
2															
3															
4															
5															
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ:															

"Бүртгэгдээгүй өгөгдлийн дугаар:

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн албан тушаалтан: /...../

Хяналт шинжилгээ, үнэлгээтэй танилцсан албан тушаалтан: /...../



Handwritten signature or mark.